

## Гэр бүлүүдэд зориулсан COVID-19-н тухай зөвлөгөө \*Greater Sydney-гийн нутаг дэвсгэр дэх сургуулиудын үйл ажиллагаа

NSW мужийн Боловсролын Яам болон NSW мужийн Эрүүл Мэндийн Яам COVID-19-н дэгдэлтийн эсрэг хариу арга хэмжээ авахаар хамтран ажиллаж байна.

\*Greater Sydney (үүнд: Blue Mountains, Central Coast, Wollongong and Shellharbour) дахь сургуулиуд NSW мужийн Эрүүл Мэндийн Яамны гэрээсээ суралцах зааварчилгааг даган мөрдөж байна. Сургуульд ирж суралцах шаардлага бүхий бүх сурагчдад сургуулиуд бүрэн нээлттэй байгаа. COVID-19-н ялимгүй ч гэсэн шинж тэмдэг ([COVID-19 symptoms](#)) илэрч байвал сурагч, эцэг эх эсвэл хүүхдийг сургууль дээр ирэхийг хориглох ба шинжилгээний сөрөг хариу авах, мөн уг өвчний шинж тэмдэггүй болох хүртлээ сургууль дээр ирэхгүй байх ёстой.

### Маск болон нүүрний хаалтууд

Сургууль дээр байх хугацаанд сургуулийн дотор орчинд маск эсвэл нүүрний хаалтыг заавал зүүхийг дараах хүмүүсээс шаардах болно:

- 7 дугаар анги болон түүнээс дээшхи ангийн бүх сурагчид
- сургуулийн бүх багш албан хаагчид.

Эдгээр дүрмийн шаардлагаас чөлөөлөгдө зарим нэг шалтгаанууд байж болно. Энэ талаар NSW мужийн Засгийн Газрын вэб хуудаснаас ([Face mask rules on the NSW Government website](#)) дэлгэрэнгүй мэдээллийг аварай.

### Зочид

Сургуулийн талбай дээр нэн шаардлагагүй зочид орохыг хориглоно.

Сурагчдыг сургуульд хүргэж өгөх болон тосч авахтай холбоотой гарсан өөрчлөлтийн талаарх сургуулийн зааварчилгааг эцэг эх, асран хамгаалагчид мөрдөх ёстой. Тухайлбал, аюулгүй нөхцөл хангагдаж байгаа тохиолдолд эцэг эхчүүд хүүхдээ хүргэж өгөх мөн тосч авахдаа машинаасаа гарахгүй байх ёстой. Гэхдээ Сургуулийн Бус Цагийн Асрах Үйлчилгээнд (Out of School Hours Care (OOSH)) заавал гарын үсэг шаарддаг тул уг дүрэм хамаарахгүй болно.

Эцэг эхчүүд дараах журмыг мөрдөх ёстой. Үүнд:

- сургуулийн эргэн тойрон дэх бүсэд зай барих дүрмийг мөрдөж сургуулийн хаалганы гадна бөөгнөрөл үүсгэхгүй байх
- сургуулийн байр талбай наас гадна байх. Зарим шалтгааны улмаас, тухайлбал, Тусгай Сургуулиуд (Schools for Specific Purposes (SSP)), эмзэг нөхцөлтэй сурагчид эсвэл хөгжлийн бэрхшээлтэй сурагчид дээрх дүрмийн шаардлагаас чөлөөлөх боломжтой.
- сургууль руу орохдоо маск зүүх дүрмийг баримтлах бөгөөд мөн Service NSW QR code уншуулан бүртгүүлэх.

### HSC сурагчид

HSC сурагчид гэрээсээ хичээллэх боломжгүй нөхцөлд хичээл, төслийн хичээл болон шалгалтандаа бэлдэх зорилгоор сургууль дээр ирэх боломжтой. Сургууль дээр ирж буй сурагчид COVID-н аюулгүйн дүрмийг хатуу баримтлах ёстой.

### Утсан Орчуулгын Үйлчилгээ

Хэрвээ танд илүү дэлгэрэнгүй мэдээлэл хэрэгтэй бол сургуулийн захиралтай утсаар холбогдоорой. Хэрвээ танд орчуулагч хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээ болох 131 450 руу залган өөрийн хэл дээрх орчуулагчийг хүсээрэй. Энэхүү үйлчилгээ нь үнэ төлбөргүй юм.